

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3.Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.9. Аудитын илрүүлэлт	17
Залруулсан алдаа.....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	18
4. Менежментийн захидал.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ШИНЭ ЭХЛЭЛ
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Н.ОЮУНГЭРЭЛ ТАНАА

2021.02.25 № 07/579
танай _____-ны № _____-т

Аудитын санал, дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалтай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 5 арга хэмжээ нь дэлхийн нийтийг хамарсан ковид-19 цар тахлаас шалтгаалан цуцлагдаж, үлдсэн 45 арга хэмжээг дунджаар 99.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>131,477,557.34</u>	<u>137,510,960.34</u>
33	АВЛАГА	00.00	330,548.00
335	Бусад авлага	00.00	330,548.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	330,548.00
35	БАРАА МАТЕРИАЛ	131,477,557.34	137,180,412.34
351	Түүхий эд материал	72,657,150.27	74,015,900.27
35110	Тусгай зориулалттай материал	70,172,332.27	70,772,782.27
35130	Эм боох материал	2,484,818.00	3,243,118.00
354	Хангамжийн материал	58,820,407.07	63,164,512.07
35410	Бичиг хэргийн материал	2,651,744.00	3,964,640.00
35420	Аж ахуйн материал	30,260,085.37	33,688,853.37
35440	Түлш, шатах тослох материал	5,572,367.80	4,991,808.80
35470	Бусад хангамжийн материал	20,336,209.90	20,519,209.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,632,766,906.39</u>	<u>2,700,744,840.45</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>1,632,766,906.39</u>	<u>2,700,744,840.45</u>
392	Биет хөрөнгө	<u>1,632,766,906.39</u>	<u>2,700,744,840.45</u>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,439,703,470.00	2,533,380,583.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-23,995,057.80	-60,333,101.46
39203	Авто-тээврийн хэрэгсэл	60,800,000.00	60,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-60,800,000.00	-60,800,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	273,173,439.24	270,427,674.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	-206,902,307.38	-227,457,984.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	148,425,850.64	148,425,850.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	-90,201,397.31	-102,492,624.43
39217	Ном	92,562,909.00	138,794,443.00
39301	Програм хангамж	825,000.00	825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-825,000.00	-825,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,764,244,463.73</u>	<u>2,838,255,800.79</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>330,548.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	330,548.00
413	Өглөг	00.00	330,548.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	330,548.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,764,244,463.73</u>	<u>2,837,925,252.79</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>1,764,244,463.73</u>	<u>2,837,925,252.79</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,655,454,175.78	1,655,454,175.78
51101	Өмч: - төрийн	1,655,454,175.78	1,655,454,175.78
512	Хуримтлагдсан үр дүн	<u>-225,262,070.98</u>	<u>848,418,718.08</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	-225,262,070.98	-227,928,188.55
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,076,346,906.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	334,052,358.93	334,052,358.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,764,244,463.73</u>	<u>2,838,255,800.79</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,055,493,401.64	2,276,119,229.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,446,476.64	1,149,881,732.05
120	Нийтлэг татварын бус орлого	3,278,638.00	1,149,418,613.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	184,706.00	1,136,770,913.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	184,706.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	1,136,770,913.00
120009	Бусад орлого	3,093,932.00	12,647,700.00
122	Тусламжийн орлого	22,167,838.64	463,119.05
122001	Хандив тусламж /дотоод/	22,167,838.64	463,119.05
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,030,046,925.00	1,126,237,497.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,008,078,800.00	1,126,237,497.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,008,078,800.00	1,126,237,497.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,968,125.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,968,125.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,101,399,783.13	1,199,772,322.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,101,399,783.13	1,199,772,322.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,035,675,166.79	990,317,098.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	724,555,021.00	766,149,857.58
210101	Үндсэн цалин	724,555,021.00	766,149,857.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,019,510.00	97,827,306.00
210201	Тэтгэврийн даатгал	62,533,919.00	67,346,754.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,356,931.00	7,923,147.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,770,346.00	6,157,080.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,396,211.00	1,490,941.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,962,103.00	14,909,384.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,931,743.73	18,685,946.73
210301	Гэрэл, цахилгаан	8,442,263.00	5,511,207.00
210302	Түлш, халаалт	10,066,338.76	10,769,330.88
210303	Цэвэр, бохир ус	2,973,141.97	1,905,408.85
210304	Байрны түрээс	450,000.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,784,603.79	13,531,653.43
210401	Бичиг хэрэг	11,125,367.28	4,897,144.00
210402	Тээвэр, шатахуун	2,041,125.00	1,053,678.05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,407,270.78	4,181,493.38
210404	Ном, хэвлэл	151,400.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	460,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,599,440.73	3,399,338.00
2105	Нормативт зардал	1,206,804.00	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,206,804.00	300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,780,990.00	8,193,093.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,476,766.00	8,070,693.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,824.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	122,400.00	122,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	131,396,494.27	85,629,241.37
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	63,788,309.88	16,364,646.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,608,184.39	69,264,595.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,724,616.34	209,455,224.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,900,000.00	15,341,797.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	14,521,797.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,900,000.00	820,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	63,824,616.34	194,113,427.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	63,824,616.34	194,113,427.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-45,906,381.49</u>	<u>1,076,346,906.63</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-45,906,381.49</u>	<u>1,076,346,906.63</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,030,231,631.00</u>	<u>1,138,885,197.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	184,706.00	12,647,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	184,706.00	12,647,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	184,706.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	184,706.00	00.00
120009	Бусад орлого	00.00	12,647,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,030,046,925.00	1,126,237,497.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,008,078,800.00	1,126,237,497.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,008,078,800.00	1,126,237,497.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,968,125.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,968,125.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,030,231,631.00</u>	<u>1,135,747,463.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,030,231,631.00	1,135,747,463.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	964,507,014.66	926,292,238.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	703,256,808.00	753,761,345.58
210101	Үндсэн цалин	396,307,578.00	403,057,840.00
210102	Нэмэгдэл	228,914,570.00	272,993,686.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,204,117.00	32,547,924.00
210104	Урамшуулал	43,830,543.00	45,161,894.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,207,915.00	97,094,119.00
210201	Тэтгэврийн даатгал	59,722,324.00	66,613,567.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,356,931.00	7,923,147.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,770,346.00	6,157,080.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,396,211.00	1,490,941.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,962,103.00	14,909,384.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,931,743.73	18,685,946.73
210301	Гэрэл, цахилгаан	8,535,549.00	5,511,207.00
210302	Түлш, халаалт	10,066,338.76	10,769,330.88
210303	Цэвэр, бохир ус	2,879,855.97	1,905,408.85
210304	Байрны түрээс	450,000.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,703,541.78	9,211,423.38
210401	Бичиг хэрэг	3,119,800.00	2,692,330.00
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	227,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,407,270.78	4,181,493.38
210404	Ном, хэвлэл	11,121,555.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	460,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,594,916.00	2,110,500.00
2105	Нормативт зардал	341,804.00	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	341,804.00	300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,164,258.00	23,790,191.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,860,034.00	23,667,791.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,824.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	122,400.00	122,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,900,944.15	23,449,213.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	60,900,944.15	23,449,213.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,724,616.34	209,455,224.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,900,000.00	15,341,797.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	14,521,797.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,900,000.00	820,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	63,824,616.34	194,113,427.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	63,824,616.34	194,113,427.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	3,137,734.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	3,137,734.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	3,137,734.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	3,137,734.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	3,137,734.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-3,137,734.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,655,454,175.78	334,052,358.93	-225,262,070.98	1,764,244,463.73
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,655,454,175.78	334,052,358.93	-225,262,070.98	1,764,244,463.73
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,655,454,175.78	334,052,358.93	-225,262,070.98	1,764,244,463.73
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-2,666,117.57	-2,666,117.57
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,655,454,175.78	334,052,358.93	-227,928,188.55	1,761,578,346.16
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,076,346,906.63	1,076,346,906.63
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,655,454,175.78	334,052,358.93	848,418,718.08	2,837,925,252.79

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,151,703,300.00	944,771,769.69	206,931,530.31	82.0
УРСГАЛ ЗАРДАЛ	1,151,703,300.00	944,771,769.69	206,931,530.31	82.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,110,895,700.00	929,429,972.69	181,465,727.31	83.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	802,804,500.00	753,761,345.58	49,043,154.42	93.9
Үндсэн цалин	411,593,700.00	403,057,840.00	8,535,860.00	97.9
Нэмэгдэл	304,424,500.00	272,993,686.90	31,430,813.10	89.7
Унаа хоолны хөнгөлөлт	36,960,000.00	32,547,924.00	4,412,076.00	88.1
Урамшуулал	49,826,300.00	45,161,894.68	4,664,405.32	90.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,378,700.00	97,094,119.00	11,284,581.00	89.6
Тэтгэврийн даатгал	76,266,400.00	66,613,567.00	9,652,833.00	87.3
Тэтгэмжийн даатгал	8,028,000.00	7,923,147.00	104,853.00	98.7
ҮОМШӨ-ний даатгал	6,422,500.00	6,157,080.00	265,420.00	95.9
Ажилгүйдлийн даатгал	1,605,700.00	1,490,941.00	114,759.00	92.9
Эрүүл мэндийн даатгал	16,056,100.00	14,909,384.00	1,146,716.00	92.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,210,900.00	18,685,946.73	15,524,953.27	54.6
Гэрэл, цахилгаан	14,214,900.00	5,511,207.00	8,703,693.00	38.8
Түлш, халаалт	14,695,900.00	10,769,330.88	3,926,569.12	73.3
Цэвэр, бохир ус	3,300,100.00	1,905,408.85	1,394,691.15	57.7
Байрны түрээс	2,000,000.00	500,000.00	1,500,000.00	25.0
Хангамж, бараа материалын зардал	19,482,900.00	12,349,157.38	7,133,742.62	63.4
Бичиг хэрэг	2,935,700.00	2,692,330.00	243,370.00	91.7
Тээвэр, шатахуун	2,820,000.00	227,100.00	2,592,900.00	8.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,460,000.00	4,181,493.38	3,278,506.62	56.1
Ном, хэвлэл	3,460,000.00	3,137,734.00	322,266.00	90.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	00.00	480,000.00	0.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,327,200.00	2,110,500.00	216,700.00	90.7
Нормативт зардал	360,200.00	300,000.00	60,200.00	83.3
Нормын хувцас, зөөлөн эдлэл	360,200.00	300,000.00	60,200.00	83.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,279,900.00	23,790,191.00	21,489,709.00	52.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,148,000.00	23,667,791.00	19,480,209.00	54.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	00.00	2,000,000.00	0.0
Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	122,400.00	9,500.00	92.8

Бараа үйлчилгээний бусад зардал	100,378,600.00	23,449,213.00	76,929,387.00	23.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,378,600.00	23,449,213.00	76,929,387.00	23.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,807,600.00	15,341,797.00	25,465,803.00	37.6
Бусад урсгал шилжүүлэг	40,807,600.00	15,341,797.00	25,465,803.00	37.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,987,600.00	14,521,797.00	25,465,803.00	36.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	820,000.00	820,000.00	00.00	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,151,703,300.00	944,771,769.69	206,931,530.31	82.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,151,703,300.00	932,124,069.69	219,579,230.31	80.9
Улсын төсвөөс санхүүжих	1,151,703,300.00	932,124,069.69	219,579,230.31	80.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	12,647,700.00	-12,647,700.00	0.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	12,647,700.00	-12,647,700.00	0.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	48	48	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	31	31	-	100.0
Үйлчлэх ажилтан	16	16	-	100.0

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Оюунгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө, бараа материалыг стандарт, байгууллагын бодлогын баримт бичигт заасны дагуу хүлээн зөвшөөрч бүртгэх, санхүүгийн жил бүрийн эцэст хөрөнгийн үнэ цэнэ, эдийн засгийн үр өгөөж хүртэж буй эсэхийг үнэлж, үнэлгээнд үндэслэн актлах хөрөнгө болон дахин үнэлүүлэх шаардлагатай хөрөнгийн жагсаалтыг харьяа яамандаа хүргүүлж байх, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, гэрээгээр Хүлэгтхүннү аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Ичинхорол, аудиторын туслах Э.Цолмон нар хариуцаж хэрэгжүүлэв.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 сарын 13-ны өдрийн 02/04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн эрхэм зорилго нь Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, үнэт зүйл бүхий, хүмүүнлэг, монгол иргэнийг төлөвшүүлэхэд оршино.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн үндсэн үйл ажиллагаа нь Монгол улсын бага, суурь, бүрэн дунд боловсролын судалгаа, шинжилгээ, туршилт, Кембрижийн олон улсын хөтөлбөрөөр монгол, англи хос хэлний сургалт эрхлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга,
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай,
- 2020 оны Засгийн газрын 32 дугаар тогтоол “Боловсролын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай”,
- 2020 оны Засгийн газрын 51 дугаар тогтоол “Боловсрол, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай”,
- Ковид-19-тэй холбоотойгоор Засгийн газрын 168, 183 дугаар тогтоолууд

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургууль санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2019 оноос 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, 3 асуудалд зөрчил илрүүлж, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, холбогдох хууль тогтоомж, журмыг мөрдөн ажиллах, өмнөх жилийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар нийт 6 зөвлөмж өгсөн байна. Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас дотоод аудитын тайланг 2021 оны 1 дүгээр сарын 26-нд хүргүүлэхээр төлөвлөж, танилцуулан хөл хорионоос шалтгаалж сургуульд 2021 оны 2 дугаар сарын 24-ний өдөр өгсөн.

Аудитын зүгээс дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “Нийт зардал”-ыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 1,196,171.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 23,923.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,074,011.3 мянган төгрөгөөр буюу 61 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна. Өөрчлөлтийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		330.6	330.6
Бараа материал	131,477.6	137,180.4	5,702.8
Үндсэн хөрөнгө	1,632,766.9	2,700,744.8	1,067,977.9
Нийт хөрөнгө	1,764,244.5	2,838,255.8	1,074,011.3
Өр төлбөр		330.6	330.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,764,244.5	2,837,925.2	1,073,680.7

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,764,244.5	2,838,255.8	1,074,011.3
---	--------------------	--------------------	--------------------

Авлага дансны үлдэгдэл 330.6 мянган төгрөг болж өссөн нь тайлант онд татварын албанд илүү төлөлт хийснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 137,180.4 мянган төгрөг болж 5,702.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилд хэрэглэхээр бичиг хэрэг, эм боох материал, аж ахуйн материал худалдан авсан боловч ковид-19-тэй холбоотойгоор сургалтын үйл ажиллагаа цахимаар явагдсанаас сургалтын жилд хэрэглэгдэх хангамжийн зүйлс тавьж олгогдоогүй үлдсэн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд 2016-2019 онд худалдан авсан, удаан эргэлттэй 128,857.9 мянган төгрөгийн 666 нэр төрлийн бараа материал байна. Үүнээс шатахууны үлдэгдэлд 2-3 жил хэрэглэгдэх шатахууны нөөц байгаа бөгөөд өмнөх аудитаас үүнтэй холбоотой зөвлөмж авч, зөвлөмжийн дагуу тайлант онд нэмж худалдан авалт хийгээгүй байна. Түүнчлэн үлдсэн бараа материалаас сургалтад олон удаа хэрэглэгддэг, хэрэглэх үедээ нэгээс дээш жил ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн шинж чанартай бараа материал байсан бөгөөд аудитын явцад горим хэрэгжүүлж, зөвлөмж өгч ажилласан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,700,744.8 мянган төгрөг болж 1,067,977.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилд Боловсрол, шинжлэх ухааны яамны захиалгаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан 1,093,677.1 мянган төгрөгийн барилгын өргөтгөлийг хүлээн авснаас шалтгаалжээ. Үүнээс гадна үндсэн хөрөнгийн данс нь үнэ төлбөргүй шилжиж ирсэн 43,093.8 мянган төгрөгийн хөрөнгө, тайлант жилд худалдан авсан 3,137.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-аас ирсэн А-1/1823 шийдвэрээр акталсан 2,745.8 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 330.6 мянган төгрөг болж өссөн нь ажилчдаас тайлант жилийн хувь хүний орлогын албан татварыг илүү суутгаж, тооцоо үүсгэснээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,837,925.2 мянган төгрөг болж 1,073,680.7 мянган төгрөгөөр буюу 61 хувиар, санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,220,625.8 мянган төгрөгөөр буюу 116 хувиар тус тус өссөн нь дээр дурдсан барилгын өргөтгөлийг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 98,372.54 мянган төгрөгөөр буюу 9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь нэмэгдэл цалин хөлс болон түүнээс тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлууд байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,366,400.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,366,400.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 214,696.7 мянган төгрөгөөр бууруулж 1,151,703.3 мянган төгрөгөөр баталсан байна. Дээд шатны төсвийн захирагчаас өмнөх онд баталсан төсөвтэй харьцуулан 214,696.7 мянган төгрөгөөр бууруулахад 32,035.5 мянган төгрөг нь үндсэн цалин, 51,000.0 мянган төгрөг нь гэрээт ажлын цалин, 25,130.0 мянган төгрөг нь нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардал, 27,083.9 мянган төгрөг нь ашиглалтын зардал, 18,123.7 мянган төгрөг нь тээвэр, шатахууны зардал, 15,320.0 мянган төгрөг нь ном хэвлэлийн зардал, 18,470.0 мянган төгрөг нь дотоод томилолтын зардал, 6,296.0 мянган төгрөг нь шуудан, холбоо, интернэтийн төлбөр гэсэн 8 төрлийн

зардал голлох нөлөө үзүүлсэн байна. Өмнөх оны батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургууль нь нэмэгдэл цалин, гэрээт ажлын цалин, ашиглалтын зардал, тээвэр, шатахууны зардал, шуудан, холбоо, интернэтийн төлбөр, дотоод томилолтын зардлыг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 зорилтын хүрээнд 50 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,151,703.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,151,703.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,126,237.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 12,647.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 944,771.8 мянган төгрөгийг зарцуулж, 194,113.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 944,771.8 мянган төгрөг буюу 82 хувьтай байгаа нь бараа үйлчилгээний бусад зардлыг 76,929.4 мянган төгрөгөөр, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 49,043.2 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 11,284.6 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 25,465.8 төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 21,489.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 15,525.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 7,133.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь дэлхий нийтийг хамарч буй ковид-19 цар тахалтай холбоотойгоор 5 арга хэмжээ цуцлагдаж, үйл ажиллагаа тодорхой хэмжээгээр хумигдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургууль нь тайлант жилд нэмэлт санхүүжилт аваагүй.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 39 мэдээллээс хугацаандаа оруулсан 33 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байгаа бөгөөд 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан болон цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 149,996.0 мянган төгрөгийн зөрчилд 15,088.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлснээс 2

албан шаардлагыг биелүүлж, 1 албан шаардлагыг биелүүлээгүй байна. Аудитаар өгсөн 149,996.0 мянган төгрөгийн 6 зөвлөмжийн хэрэгжилт 83.3% хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь /тоо/
Акт							
Албан шаардлага	3	15,088.6	2	15,088.6	1	0.0	0.0
Зөвлөмж	6	134,907.4	5	134,907.4	1	0.0	83.3
Нийт дүн	9	149,996.0	7	149,996.0	2	0.0	88.9

Хэрэгжүүлээгүй 1 зөвлөмжид албан шаардлага тогтоосон. Түүнчлэн 1 албан шаардлагыг хэрэгжүүлэхээр ажилласан боловч шалгагдагч байгууллагаас хамаараагүй, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээс хамааран шийдвэрлэгдээгүй тул илрүүлэлтээс хасаж, үүнийг биелэлтийн хувьд харгалзан үзэж дундаж хувийг тооцсон болно. Биелүүлээгүй албан шаардлагыг “Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд” хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлан оруулав.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,481,348.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 6,267.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,474,751.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 330.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд барилга, барилгын өргөтгөлийн тайлант жилийн элэгдлийн зардлыг 3,600.9 мянган төгрөгөөр, өмнөх тайлант жилүүдийн элэгдлийн зардлыг 2,666.1 мянган төгрөгөөр, хуримтлагдсан элэгдлийг 6,267.0 мянган төгрөгөөр тус тус дутуу тооцож бүртгэснийг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 2,475,081.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 2,474,751.1 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроосон 2 мэдээлэл, мөн 1,136,770.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн дүнг “Хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан”-ийн хэсэгт, 1,138,837.5 мянган төгрөгийн мөнгөн орлого, 199,142.7 мянган төгрөгийн мөнгөн зарлагын мэдээллийг “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”-ний хэсэгт тус тус байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;...", 5.5-д "Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна." гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2. Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах талаар өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 4.1.-д "Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна: ... 4.1.5. өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт;" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 330.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Тайлант жилд анхаарал татахуйц дараах асуудлууд гарсан байна. Үүнд:

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаас сургуульд сургуулийн барилгыг үл хөдлөх эд хөрөнгийн болон газар эзэмших улсын бүртгэлийн гэрчилгээтэй болох талаар албан шаардлага өгсөн. Уг барилга нь анх тус сургуулийг үүсгэн байгуулах үед Монгени сургуулийн эзэмшлийн газар дээр баригдаж буй барилгад үйл ажиллагаагаа явуулахыг харьяа яамнаас оноосон барилга юм. Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн удирдлага аудитаас өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэхээр харьяа яамандаа хүсэлт гаргасан бөгөөд харьяа яам нь холбогдох эрх бүхий газруудад уламжилсан байна. Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас тус асуудлыг "Газар, барилгажуулалтын мэргэжлийн зөвлөл"-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэх тул холбогдох бичиг баримтын бүрдлийг ханган Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд хандах талаар мэдэгдсэн бөгөөд энэ асуудлыг Монгени сургуулиас хүлээн зөвшөөрөхгүй, мөн өөрийн газарт халдаж байгаа талаарх албан бичгийг тус сургуульд ирүүлсэн. Иймд дээрх албан шаардлагыг сургуулийн удирдлага шийдвэрлэх боломжгүй байдал үүссэн, холбогдох эрх бүхий байгууллагуудын шийдвэрээс хамаарах тул уг асуудал шийдвэрлэгдээгүй байна.
2. Тайлант жилд үнэ төлбөргүй хүлээн авсан 524 ширхэг номыг тэг төгрөгөөр үнэлэн орлогод авсан зөрчилд үнэ цэнийг тогтоож, үнэлж бүртгэх талаар зөвлөмж өгсөн боловч байгууллагын удирдлагаас уг хөрөнгүүдийг үнэлж бүртгэлгүй, актлах саналтай байгаагаа илэрхийлсэн. Уг асуудлын талаар "Менежментийн захидал"-ийн 3 дугаар хэсэгт илүү дэлгэрэнгүй тусгав.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ өртгөө нөхсөн 271,872.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 113 нэр төрлийн хөрөнгөөс цаашид ашиглах боломжгүй, эдийн засгийн үр өгөөжгүй болсон 184,274.4 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 42 нэр төрлийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөөгүй, цаашид ашиглах боломжтой, эдийн засгийн үр өгөөж хүртэж буй 87,597.7 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 71 нэр төрлийн хөрөнгийг дахин үнэлүүлээгүй байна.

Энэ нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн 82(б)-д "Хөрөнгийг данснаас хасах буюу борлуулах эсвэл түүний ашиглалтаас ирээдүйн эдийн засгийн үр өгөөж, үйлчилгээний чадавхи хүртэхгүй болсон үед хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө", 67-д "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянах ёстой" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд толилуулсан үндсэн хөрөнгийн дүн буруу илэрхийлэгдэх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид УСНББОУС-т заасны дагуу санхүүгийн жил бүрийн эцэст хөрөнгийн үнэ цэнэ, эдийн засгийн үр өгөөж хүртэж буй эсэхийг үнэлэн, үнэлгээнд үндэслэн актлах хөрөнгө болон дахин үнэлүүлэх шаардлагатай хөрөнгийн жагсаалтыг харьяа яамандаа хүргүүлэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант жилд удаан эргэлттэй, материаллаг хэмжээний 168 нэр төрлийн бараа материал байгаагаас сургалтад олон удаа хэрэглэгддэг, хэрэглэх үедээ нэгээс дээш жил ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалаар хүлээн зөвшөөрсөн байна.

Энэ нь УСНББОУС-12 Бараа материалын 44-т "Холбогдох орлого байхгүй бараа материалыг барааг хуваарилах буюу холбогдох үйлчилгээг үзүүлэхэд гарсан зардал гэж хүлээн зөвшөөрнө", УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн 13-т "Үндсэн хөрөнгө гэдэг нь байгууллагын эзэмшилд байгаа ба нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм", БШУС-ын 2017 онд баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн Бараа материалын бодлогын Бараа материалд хамаарах зүйлд "Байгууллагын үндсэн ба үндсэн бус үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардлагатай, хэрэглэсэн даруйдаа үйлчилгээний зардалд шингэдэг, байгууллагын эзэмшилд байгаа 1 жилийн дотор хэрэглэгдэх зүйл" гэж заасныг тус тус зөрчиж, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд толилуулсан бараа материал, үндсэн хөрөнгийн дүн буруу илэрхийлэгдэх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Нэр бүхий 168 нэр төрлийн удаан эргэлттэй бараа материалаас сургалтад олон удаа хэрэглэгддэг, хэрэглэх үедээ нэгээс дээш жил ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан бараа материалыг УСНББОУС-12 Бараа материал болон Боловсрол, шинжлэх ухааны ухааны яамны баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн Бараа материал, Үндсэн хөрөнгийн тодорхойлолт болон хамаарах зүйлсэд нийцүүлэн зөв ангилан бүртгэх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид УСНББОУС болон Боловсрол, шинжлэх ухааны яамны баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн Бараа материалын бодлогыг анхаарч, нягтлан шалгаж ажиллах болно.

3. Үнэ төлбөргүй хүлээн авсан орлоготой холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант жилд үнэ төлбөргүй хүлээн авсан 524 ширхэг номыг тэг төгрөгөөр үнэлэн орлогод авсан зөрчил гаргасан нь УСНББОУС-23 Арилжааны бус ажил үйлчилгээний орлогын 97-д "Бэлэг ба хандив, үүнд хариу төлбөргүй барааг анхны хүлээн зөвшөөрөлтөөр түүнийг олж авсан өдрийн бодит үнэ цэнээр хэмжих бөгөөд идэвхтэй зах зээлийн үнэ эсвэл үнэлгээгээр бодит үнэ цэнийг тогтоож болох" гэж заасныг зөрчиж, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд толилуулсан үнэ төлбөргүй орлого, үндсэн хөрөнгийн дүн буруу илэрхийлэгдэх.

3.3. Өгсөн зөвлөмж:

Дараагийн санхүүгийн жилд нэр бүхий 524 ширхэг номын үнэ цэнийг тогтоож, үнэлж бүртгэх, хэрэгцээ хангахгүй номыг актлах саналаа харьяа яамандаа хүргүүлж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Сургалтын агуулга болон хөтөлбөр шинэчлэгдсэнтэй холбоотой 2011-2013 онд орлогод хүлээн зөвшөөрсөн номын жагсаалтыг гаргаж актлах саналаа хүргүүлж ажиллана.

4. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тайлант жилд 330.6 мянган төгрөгийн авлага, өглөг тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

4.2. Эрсдэл:

Төсвийн тухай хуулийн холбогдох заалт хэрэгжихгүй, санхүү, төсвийн зохистой удирдлага алдагдах;

4.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид авлага, өглөг үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид өр, авлага үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ Эхлэл сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02.23			САГ-2021/78/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ Эхлэл сургууль		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах талаар өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй.	0.0	Албан шаардлага	Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Дотоод хяналтын ажилтан	Н.Оюунгэрэл, С.Алтанзул
2	Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроосон 2 мэдээлэл, мөн 1,136,770.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн дүнг “Хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан”-ийн хэсэгт, 1,138,837.5 мянган төгрөгийн мөнгөн орлого, 199,142.7 мянган төгрөгийн мөнгөн зарлагын мэдээллийг “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”-ний хэсэгт тус тус байршуулаагүй.	2,474,751.1	Албан шаардлага	Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Нягтлан бодогч	Н.Оюунгэрэл Д.Наранцэцэг
3	Тайлант жилд 330.6 мянган төгрөгийн авлага, өглөг тайлагнасан байна.	330.6	Зөвлөмж өгсөн	Нягтлан бодогч	Д.Наранцэцэг
4	Тайлант жилд удаан эргэлттэй материаллаг хэмжээний 168 нэр төрлийн бараа материал байгаагаас сургалтад олон удаа хэрэглэгддэг, хэрэглэх үедээ нэгээс дээш жил ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалаар хүлээн зөвшөөрсөн байна.	0.0	Зөвлөмж өгсөн	Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Нягтлан бодогч	Н.Оюунгэрэл Д.Наранцэцэг
5	Элэгдлээрээ өртгөө нөхсөн 271,872.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 113 нэр төрлийн хөрөнгөөс цаашид ашиглах боломжгүй, эдийн засгийн үр өгөөжгүй болсон 184,274.4 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 42 нэр төрлийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөөгүй, цаашид ашиглах боломжтой, эдийн засгийн үр өгөөж хүртэж буй 87,597.7 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 71 нэр төрлийн хөрөнгийг дахин үнэлүүлээгүй байна.	0.0	Зөвлөмж өгсөн	Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Нягтлан бодогч	Н.Оюунгэрэл Д.Наранцэцэг
6	Тайлант жилд үнэ төлбөргүй хүлээн авсан 524 ширхэг номыг тэг төгрөгөөр үнэлэн орлогод авсан зөрчил гаргасан.	0.0	Зөвлөмж өгсөн	Нягтлан бодогч	Д.Наранцэцэг
ДҮН		2,475,081.7			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 2021/40160058

Улаанбаатар хот

САН 2021/78/СТА-ТЧЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах талаар өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 4.1.-д "Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна: ... 4.1.5-д" өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт;" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухайн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т зааснаар "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийн таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаал баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, дотоод хяналтыг сайжруулан, алдаа зөрчлийг арилгаж биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Оюунгэрэл, Нягтлан бодогч Д.Наранцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН
ХҮЛЭГТХҮННҮ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Ч.ИЧИНХОРОЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 203/АД160058

Улаанбаатар хот

САГ-2021/78/СТА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроосон 2 мэдээлэл, мөн 1,136,770.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн дүнг "Хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан"-ийн хэсэгт, 1,138,837.5 мянган төгрөгийн мөнгөн орлого, 199,142.7 мянган төгрөгийн мөнгөн зарлагын мэдээллийг "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ"-ний хэсэгт тус тус 2 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1-д "энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;...", 5.5-д "шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна." гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухайн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т зааснаар "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийн таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаал баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв, ил тод, бүрэн байршуулж зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Оюунгэрэл, Нягтлан бодогч Д.Наранцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН

ХҮЛЭГТХҮННУ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Ч.ИЧИНХОРОЛ

[illegible]

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

[illegible]